



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 5/2021

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйл 5.1, 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3, Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 1.3, ТУЗ-ийн 2019 оны 26-р тогтоол, Хамтын гэрээний 6.2, компанийн 2022 оны Ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн Реле хамгаалалт автоматикийн албаны Төвлөрсөн автоматикийн системийн инженер П.Энхболор, Судалгаа хөгжлийн албаны Судалгаа хөгжлийн инженер С.Тэмүүлэн нарыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Эрчим хүчний сургуулийн PSIM MATLAB программ хангамж ашиглалтын сургалтад 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 09 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.
2. Ажилтнуудын сургалтын зардал болох 1,000,000 (нэг сая) төгрөгийг холбогдох сургалтын зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан (Т.Бямбажав)-д зөвшөөрсүгэй.
3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын алба (Б.Биндэръяа)-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.БАЛЖИННЯМ

